

Эхийг уншиж, утга санааг ойлгоё.

1. Үлгэрийн үйл явдал болон дэвшүүлсэн гол санааг ойлгож уншаарай. Ойлгох гол хоёр санаа:
 - а. Үлгэрт чухалчилсан санаа нь юу вэ?
 - б. Бидэнд үлдэх сургамж нь юу вэ?
2. Ойлголтоо цэгцлээд ярилцаарай.
3. Үлгэрт зурж онцолсон үг хэллэгийг анхаарч, утгыг нь ярилцаарай. Сайн мэдэхгүй үгийн утгыг өмнөх ба хойдох үгтэй нь холбон төсөөлж мэдэхийг хичээгээрэй. Эсвэл толь ашиглаж болно.
3. Үлгэрийг бусдадаа уншиж өгөөрэй. Найзынхаа уншиж байгааг сонсох явцдаа дараах шалгуураар үнэлгээ өгөөрэй.

Шалгуур	Маш сайн	Сайн	Дунд зэрэг	Хангалтгүй
Ойлгомжтой байдал				
Дууны өндөр, нам тохирсон байдал				
Үг хэллэг, утгын өргөлтийг зөв уншсан байдал				

ГЭР

(Монгол ардын үлгэр)

Эрт урьд цагт монголчуудын дээд өвөг үе маань хээрээр гэр, хэцээр дэр хийж явсан юм гэнэ ээ. Хөх цэнхэр дээвэртэй, хөрст ногоон дэвсгэртэй орчлон дэлхий хэмээх оосор бүчгүй нэгэн их гэрт хүн, амьтан цөмөөрөө л эвтэй сайхан амьдарч байжээ. Тэгтэл юунаас болсныг бүү мэд, нэг л мэдэхэд хоорондоо муудалцан уралцаж, хүчтэй нь хүчгүйгээ барьж идэхэд хүрэв гэнэ. Амьтад мөр мөрөө хөөн салж, зарим нь газар нүхлэн шургаж, нэг хэсэг нь усны гүнд, нөгөө хэсэг нь модны оройд гэртэй болжээ. Газар дээр үлдсэн хүн гэгч амьтанд харин хүссэн бүхнээ хийж чадах ухаан гэгчийг заяажээ.

Тэр цагт ухаанаас өөр өв хөрөнгөгүй нэгэн өвгөн амьдарч байж гэнэ. Нэгэн өдөр долоон хүүдээ "Их гэрийн үлгэрээр бага гэрийг барьж болно" гэхэд хөвгүүд нь бодоод бодоод учрыг олсонгүй гэнэ.




Өвгөн ханаран хүрээлсэн эргэн тойрны уулсыг дуурайлган бургасан хана хийв. Цасан шуурганд хаагддаг, цагийн сайханд нээгддэг тооно, тал тал тийш урссан алтан цацрагнаас нь унь, уулын араас ургасан манан будангаас туурга, дээгүүр бүрхсэн зузаан үүлсээс дээвэр хийх санаа олжээ. Түшилдэн ханхайсан уул нуруудын араар хүрдэн салхи эрчлэн

эргэж байгаа даа гэж бодуугаа хялгас томж бүслүүр хийв ээ.

Тэгээд өвгөн долоон хүүтэйгээ ханаа дэлгэж, хаалгаа босгож тооноо өргөж, униа өлгөж, туургаа барьж, дээврээ тавьж, бүслүүрээ татаад бөмбөрцөг дэлхийн хэлбэртэй бөмбөгөр цагаан гэртэй болов гэнэ. Нүүе гэвэл эвхээд ч ачдаг, бууя гэвэл дэлгээд барьдаг тийм таатай гэр бүтээсэн эцгийнхээ ухаанд хөвгүүд нь биширч, аятай тавтай аж төрөх болжээ. Гэвч үлгэр үүгээр дууссангүй, аав нь нэг өдөр хэвтэрт орж, хөвгүүдээ тойруулан суулгаад, “Төрөх нэг өдөр байхад, төгсөх нэг өдөр бий. Ханан гэрээсээ аав нь хадан гэртээ буцах боллоо. Яаж аж төрөхийг гэр чинь заагаад өгнө. Гагцхүү бүслүүрээ л чангалж яваарай” гээд насан өөд болжээ.

Хөвгүүд нь урьдын адил мөн л учрыг ололгүй гайхаж хоцров. Тэгтэл нэг өдөр гэрийнх нь бүслүүр суларчээ. Бие биедээ найдсаар хэн нь ч чангалж таталгүй суутал гэр нь яйжийж унав гэнэ. Ах дүү долоо “чамаас боллоо, танаас боллоо” гэлцэн хэрэлдэж сүүлдээ бүр таарч тохирохоо больж тарж салахдаа хүрчээ. Эцгээс үлдсэн хөрөнгийг эн тэнцүү хувааж авахаар шийдээд хана, унь, хаалга, тооно, дээвэр, туургаа салган үүрч харсан зүгтээ одоход отгон дүүд нь бүслүүрээс өөр юм үлдсэнгүй.



Ууган хүү нэгэн газар хүрч хаалгаа босгон хэрүүл уруулгүй амар жимэр сууж байтал өдөржин хурц нар төөнөөд арай л шатаачихсангүй. Удаах хүү сараалжин ханаа дэлгээд унтаж хэвттэл гэнэт ширүүн бороо асгаж, аянга тасхийж эгээтэй л ниргэчихсэнгүй.

Дараах хүү туургандаа хоргодон суутал уулын үер урсгаад явчих шахав. Бас нэг нь дээвэр дороо амарч хэвттэл хуй салхи босож хуу татаад хаяж гэнэ. Нөгөө нь толгой дээрээ тооноо өргөөд сууж байтал шөнө болж, араатан чоно тал талд нь архиралдаж золтой л хүү татчихсангүй.

Униа боож шовойлгон хоргодож суусан нэгийг нь хүйтэн жавар хайрч хөлдүүс болгох дөхөв гэнэ. Бүслүүрээс ондоо юм үлдээгүй болохоор отгон дүү нь бүр ч хэцүү байсан нь мэдээж. Тэгтэл нэг өдөр түүн дээр хана үүрсэн ах нь буцаад иржээ. Удаах ах нар нь удалгүй хаалга, тооно, унь, дээвэр, туургаа үүрсээр ар араасаа цувран айсуй. Тийнхүү долоон хүү буурал эцгийнхээ гэрээс үгний учрыг сая л ухаарч, түүнээс хойш, үеийн үед, өргөө цагаан гэрээ эвийн сүлд болгон дээдэлсээр амар сайхандаа жаргажээ.

Эхийг задлан шинжилцгээе.

1. Үлгэрийн эхлэл, гол, төгсгөл хэсгийг зааглан тодорхойлно. Үүний тулд эхлээд эдгээр хэсэг тус бүрийн гол санааг тодотгоход чухал үүрэгтэй түлхүүр үгсийг олж, цэгийн оронд бичээрэй.

Гэр	(эхлэл)
	(үндсэн)
	(төгсгөл)

2. Үлгэрийн хэсэг бүрд ямар санаа агуулагдсаныг дээрх түлхүүр үгсийг ашиглан 1- 2 өгүүлбэрээр тодорхойлно.

Эхлэл хэсэг:.....

Үндсэн хэсэг:.....

Төгсгөл хэсэг:.....

3. Үлгэрийн үйл явдал **хаана, ямар ямар орчинд өрнөж байгааг** олж тогтооё.

1. “ Үүний тулд:

- Хайрцаг дотор буй орон зай заасан үгсийг үйл явдлын дарааллаар байрлуулъя. Ингэхдээ:
- Эхлээд хайрцаг доторх орон зай заасан үгсийг дараалуулна.
- Дараа нь хайрцгуудыг үйл явдлын орон зайн дарааллаар байрлуулна.
- Дээрх дарааллаа үлгэрийн эхтэй тохируулан шалгана.

модны орой, нүх, усны гүн, газар

харсан зүгтээ, тал талд нь, салан одох, нэгэн газар, дээвэр дороо, толгой дээрээ



газар, тэнгэр, орчлон дэлхий, хээр

буцаж ирэх, ар араасаа, цувран

4. Үлгэрийн үйл явдал **ямар дарааллаар өрнөснийг (цаг хугацааны дараалал)** –ийг олж тогтооё. Үүний тулд:

Доор цаг хугацаа заасан бүлэг үгсийг түүвэрлэн жагсаасан байгаа. Эдгээр үгсийг эхээс олж хараад, үйл явдлын дарааллаар байрлуулан, өгүүлбэрээ гүйцээн хэлээрэй. Зөв дараалалд орсон эсэхийг хянаарай.

нэгэн өдөр(долоон.....)	төрөх нэг өдөр, төгсөх нэг өдөр.....
урьдын адил мөн л.....	



- Дээрх үгсэд асуулт тавиад үз, үйл явдлын юуг нь заасан байна вэ?
- Аливаа эхийн доторх цаг хугацаа заасан ийм үгс үйл явдал болсон дарааллыг заахад ямар үүрэгтэй байна вэ? Ойлголтоо цэгцлэн тайлбарлацгаая.

5. “Гэр” үлгэрт ах дүү нар муудалцан салан явж байгаа, эргэн нэгдэж байгаагийн учир шалтгааныг жишээ баримтаар **НОТОЛЖ ЯРЬЯ**.

Учир шалтгаан гэж юу вэ?

Энэ ямар учиртай юм бэ? гэж асуудаг. Юм бүхэн, болж байгаа үйл явдал бүхэн ямар нэг шалтгааны улмаас бий болдог. Эхний үйл явдал дараагийн үйл явдал бүтэхийн үндэс болж байдаг.

Учир шалтгаан - хэрэг явдлын уг үүсгэл, шалтгаан, нөхцөл байдал, цаад учир санаа, цаад мөн чанар нь хэмээн тайлбарлажээ.

“Монгол хэлний тайлбар толь”
“Монсудар” хэвлэлийн газрын цуврал
ботийн № 1)-д:


6. Учир шалтгааны утгатай үгс байдаг. “Гэр” үлгэрээс учир шалтгааны утгатай үгсийг олж, учрыг ярилцаарай.

Учир шалтгааны тайлбарлахад “учир нь, тэгсэн учраас, тул, тулд, улмаас, болохоор” гэх мэт үг өргөн хэрэглэгддэг. Учир шалтгааны асуултад хариулагдаж байгаа үгсийг ажиглаад дүгнэлт гаргаарай.

Асуулт:	Хариулт:
<u>Ямар учраас</u> амьтад мөр мөрөө хөөн тусдаа амьдрах болов?	
Хүүхдүүд эцгийгээ биширсний <u>учир юу</u> байв?	
Эцэг нь яахын тулд хүүхдүүддээ “Яаж амьдрахыг гэр чинь заагаад өгнө. Гагцхүү гэрийнхээ бүслүүрийг л чангалж яваарай” гэж захисан бэ?	
Хөвгүүдийн гэр <u>яагаад</u> яйжийж унасан бэ?	
Хөвгүүд <u>юунаас болж</u> салж одов?	
Хөвгүүд <u>хэрхэн юуны учир</u> буцаж нийлэв?	
Хөвгүүд эцгийнхээ үгийг ойлгож ухаардаггүй байсны учир юу вэ?	

Үйл явдлыг учир шалтгааных нь дарааллаар ярья.

1. “Аяга сүү” сургамжит өгүүллийг уншаад болсон явдлыг учир шалтгааны дарааллаар ярина.
2. Ярихын өмнө дараах зураглалыг нөхөн гүйцээж томъёолно.



Нэг аяга сүү (Сургамжит өгүүллэг)

Хорвард хичээлээ тарж ирэнгүүт өөрийн гараар хийсэн ямар нэг юмыг худалдаж өл залгахаар явдаг байлаа. Мэдээж түүний зарах юм хүмүүст тийм ч хэрэгтэй биш болохоор тэр бүр амжилттай биш. Өнөөдөр тийм азгүй өдөр ажээ.

Өлсөж ядарсан хүү аргаа барж айлаас идэх юм гуйхаар шийдэж нэг хаалга тогшвол үе тэнгийн охин хаалга тайлав. Ичиж зовсон Хорвард идэх юмны оронд ус гуйлаа. Харин охин бүхнийг ойлгож байсан тул аяга сүү авчирч өглөө. Хүү сүүг удаан уугаад хармаандаа байгаа юу ч авч хүрэхгүй 10 центээ тэмтрэн хэдийг төлөх вэ? гэхэд охин “Хэрэггүй ээ. Ээж минь хийсэн сайн үйлийнхээ төлөө мөнгө авахгүй байх ёстой” гэж сургасан юм гэжээ. Хорвард чин сэтгэлээсээ талархал илэрхийлээд явлаа.

Он жилүүд урсан өнгөрч Хорвард бага сургууль, лицей, их сургуулиа төгсжээ. Цаг хугацаа урссаар л...

Алдартай Жонс Хипконсын их сургуулийн доктор Хорвард Келлигийн удирддаг эмнэлэгт нэгэн хүнд өвчтөн иржээ. Бусад эмнэлэг, эмч нар эмчлэх байтугай оношилж чадаагүй аж. Доктор Хорвард өвчтөний түүхтэй танилцахад бага нас нь өнгөрсөн танил тосгон ... бас мартаагүй нэр ... Өвчтөний өрөөнд үзлэг хийхээр орвол яг мөн. Олон жилийн өмнө өөрт нь усны оронд сүү өгсөн тэр сайхан сэтгэлтэй охин мөн байлаа. Харин өвчинд шаналсан эмэгтэй Хорвардыг хэрхэн таних билээ? Доктор Хорвард түүний төлөө бүхнийг хийжээ. Эцэст нь бүсгүйн амь нас аврагджээ.

Эмчилгээ дуусаж эмнэлгээс гарах өдөр тэр эмэгтэйн эмчилгээ хагалгаа үйлчилгээний зардал 10 000\$ болсныг сувилагч батлуулахаар докторт авч очвол Хорвард төлбөрийн хуудсан дээр ямар нэг юм бичээд эмэгтэйд аваачиж өгөхийг хүсэв. Ийм их эмчилгээ, асар их төлбөртэйг мэдэх эмэгтэй айж санаа зовсоор дугуйг задалбал “Олон жилийн өмнөх нэг аяга сүүгээр төлсөн.” Доктор Хорвард гэсэн гарын үсэг байжээ.

Үйл явдлыг учир шалтгааны дарааллаар өрнүүлэн бичье.

1. Дараах өгүүлбэрийг учир шалтгааны утгатай үг, өгүүлбэрээр дэлгэрүүлэн бичээрэй. Өгүүлбэрийг дэлгэрүүлэн бичихдээ дараах учир шалтгааны утгатай асуултыг ашиглана уу.

Яа-	Юу-
<ul style="list-style-type: none"> • яагаад? • ямар учраас? • яахын тулд? • яах гэж? 	<ul style="list-style-type: none"> • -юуны тулд? • -юуны учир? • -юуны улмаас

Бичих үлгэрчлэл:

<i>Дэлгэрүүлэх өгүүлбэр</i>	<i>асуулт</i>	<i>Дэлгэрүүлсэн өгүүлбэр</i>
Эрт дээр цагт бүх хүн, амьтан нэг доор эвтэй найртай зэрэгцэн амьдарч байснаа хамтдаа амьдрах аргагүй болж, тал тал тийшээ салан амьдарсан.	<i>Яагаад?</i>	Эрт дээр цагт бүх хүн, амьтан нэг доор эвтэй найртай зэрэгцэн амьдарч байснаа юунаас болсныг бүү мэд, тэд муудалцан уралцаж, хүчтэй нь хүчгүйгээ барьж идэхэд хүрсэн учраас хамтдаа амьдрах аргагүй болж, тал тал тийш салан амьдрах болсон. тал тал тийш салан амьдрах болсон.
Эцэг нь хүүхдүүддээ “Яаж амьдрахыг гэр чинь заагаад өгнө. Гагцхүү гэрийнхээ бүслүүрийг л чангалж яваарай” гэж захисан.		
Хорвард хичээлээ тарж ирэнгүүт өөрийн гараар хийсэн ямар нэг юмыг худалдаж өл залгахаар явдаг байлаа.		

ХЭЛ ЗҮЙ: ЖИНХЭН НЭРИЙН ХУВИЛАЛ

Тийн ялгалын утга, үүргийг мэдье.

1. Үүний тулд, дараах шүлгийг уншиж, оготны нэр ба үйлдэл нь ямар хамааралтай болохыг тайлбарлана уу.
2. Эхэд онцолсон үгэнд асуулт тавьж, тийн ялгалын **үүргийг** олж мэдээд, ярилцаарай.

Найман бор оготно буюу найман тийн ялгал

Эрт урьд цагт
Эмээлийн чинээ газарт
Ах дүү долоон оготно
Амьдран суудаг байжээ
Долоон бор оготно
Дор бүрдээ нэртэй
Нэгдүгээрт гарсан оготныг
Нэрлэх гэнэ
Харин дараагийн оготныг
Харьяалах гэнэ
Өрөвгөр жаахан гурав дахийг
Өгөх орших гэнэ
Зараа шиг арзгар үстэйг нь
Заах
Гарч гүйгээд тогтдоггүйг нь
Гарах
Үндэс сайн малтдагийг нь
Үйлдэх
Хамгийн жаахан оготныг
Хамтрах гэдэг байжээ
Ганцаараа гараад явахдаа
Газран гэрээ олохгүй
Тэнэж төөрдөг болохоор нь
Тэгж нэрлэсэн юмсанжээ
Чиг зүгээ олохдоо сайн
Чиглэх нэртэй ээж нь
Чингэлгийн доор
Чимээнээс хол амьдарна...

Тийн ялгалын нэртэй
Тийм найман оготно
Эвтэй найртай амьдран
Эрин жарныг элээжээ.
Гэнэт нэг өдөр
Гэнэтийн юм болжээ

Алгын чинээ газар дээр нь
Атгын чинээ цас оржээ
Цасаа цэвэрлэж байгаад
Шагайн чинээ шар тос олжээ
Нэрлэх нэртэй дүү нь түүнээс
Нэг том хазжээ
Харьяалах нэртэй нэг нь
Миний гээд дайрахад
Харин дараагийн оготно нь
Надад гээд булаалджээ
Зараа шиг арзгар үстэй
Заах нэртэй оготно нь
Түүнийг үлдээчихлээ гээд
Түнтгэр дүүгээ заажээ
Гарч гүйгээд тогтдоггүй
Гарах нэртэй дүү нь
Гараас булаалаа гээд
Газар саваад уначхав
Үйл ажилд дуртай
Үйлдэх нэрт дүү нь
Тосоор яах ч билээ гээд
Тоох ч үгүй суулаа
Хамтрах нэртэй
Хамгийн бага дүү нь
Надтай хуваасангүй гээд
Нал шал уйллаа
Атгын чинээ цас ч
Арилаад алга болов
Шагайн чинээ тос ч
Шалих юмгүй дуусав
Чиглэх нэртэй ээж нь тэгтэл:
“Чингэлэг рүү минь ирцгээ
Ээж нь хоол өгье
Эв найрыг л эрхэмлэ” гэжээ.

(Д.Батжаргалын "Долоон бор оготно ба долоон тийн ялгал" шүлгийг баяжуулан ашиглав)

3. Цэгийн оронд тийн ялгалын нөхцөлөөс тохирохыг бичиж, тийн ялгалын утга, үүргийг тайлбарлаарай.

- а. Хулгана ... байна
- б. Энэ хулгана ... хөөө байна.
- в. Хулгана ... хавх тавьжээ.
- г. Бид хулгана ... олж харлаа.
- д. Дүү хулгана ... айлаа.
- е. Хавх ... хулгана барьдаг.
- ё. Хулгана ... чингэлэгт хүнсний зүйл бүү хадгал.

Тийн ялгал жинхэнэ нэрийг бусад үгтэй холбох үүрэгтэй.

Тийн ялгалын нөхцөлийг буруу хэрэглэвэл өгүүлбэрийн утга, найруулга зохисгүй болно.

4. Хүснэгтээс нэрийн тийн ялгалын асуулт ба нөхцөлүүдийг ажиглан, ярилцаж мэдлэгээ цэгцэлье.

№	Тийн ялгал	Нөхцөл	Асуулт	Жишээ
1	Нэрлэх	-	хэн? юу?	хоймор, босго, өрх
2	Харьяалах	-ын,-ийн, -ы, -ий	хэний?, юуны?	хоймын, босгоны, өрхний
3	Өгөх, орших	д, -т	хэнд? юунд?	хойморт, босгонд, өрхөнд
4	Заах	-ыг, -ийг, -г	хэнийг? юуг?	хоймыг, босгыг, өрхийг
5	Гарах	-аас,-ээс, -оос,-өөс	хэнээс?, юунаас?	хоймоос,босгоноос, өрхнөөс
6	Үйлдэх	-аар,-ээр,-оор,-өөр	хэнээр?, юугаар?	хоймоор, босгоор, өрхөөр
7	Хамтрах	-тай, -тэй,-той, -тэй	хэнтэй?, юутай?	хоймортой, босготой, өрхтэй
8	Чиглэх	-руу,-рүү, -луу, -лүү	хэн рүү?, юу руу?	хоймор луу, босго руу, өрх рүү

Тийн ялгалын нөхцөлийг зөв бичиж

5. Өгүүлбэрийг хуулж бичихдээ тийн ялгалын нөхцөлөөс тохирохыг олж бичээрэй. Хоёр бүтээврийг нийлүүлж бичихэд ямар өөрчлөлт орж байгааг ажиглаарай.

Гэрийн **унь+ын** сагалдарга аль нь вэ?

Гэрийн **унь+д** хавчуулав.

Гэрийн **унь+аас** аваад ир.

Юу **юу+г** гэрийн мод... гэдэг вэ?

Бүтээвэр

язгуур + дагавар + нөхцөл

үндэс

Багана **ты** өндрийг хэмжье.

6. “гэр, дэлхий, санаа, туурга” гэсэн үгсийг 8 тийн ялгалаар хувилгаж бичээрэй.
7. Үгийг харьяалахын тийн ялгалын нөхцөлөөр хувилган бичихэд тухайн үгийн төгсгөл чухал үүрэгтэй. Дараах дүрмийг уншаад тохирох жишээг олж бичээрэй.

нөхцөл	дүрэм	Жишээг олж нөхөөрэй.
-ийн,-ын	<ul style="list-style-type: none"> • “н”-ээс бусад гийгүүлэгчээр төгссөн үгэнд залгана. • богино эгшгээр төгссөн үгэнд залгана.
-ий, -ы	<ul style="list-style-type: none"> • ”н”-ээр төгссөн үгэнд шууд залгана. • урт эгшгээр төгссөн үндсэнд “н” гийгүүлэгч жийрэглэн залгана.
-н	<ul style="list-style-type: none"> • урт ба хос эгшгээр төгссөн үгэнд шууд залгана.

8. “Гэр” үлгэрт буй “эрт, олон, дэлхий, санаа, туурга” гэсэн үгсийг заахын тийн ялгалын нөхцөлөөр хувилгаж бичрээрэй. Бичихдээ дараах дүрмийг анхаараарай.

Урт, хос эгшгээр төгссөн болон хэлний хойгуурх “н”-ээр төгссөн үгэнд заахын тийн ялгалын “-г” залгана. Бусад тохиолдолд -ыг, -ийг нөхцөлийг эгшиг зоихцох ёсыг баримтлан залгана.

9. Өгөх, оршихын тийн ялгалын нөхцөлийг залгаж бичсэн үгсийг ажиглаад өгөх оршихын тийн ялгалын нөхцөлийг зөв бичих дүрэм зохионо уу. Ямар тохиолдолд “-д”, ямар тохиолдолд “-т” нөхцөл бичиж байна вэ?

-д	-т	-/н/д
орчлонд, үед, аавд, оройд,	оосорт, тэнгэрт, газарт, хэсэгт, цагт,	ууланд, усанд, наранд,

10. Чиглэхийн тийн ялгалын нөхцөлийг үгэнд залгаж бичихэд ямар ялгаатай байгааг ажиглаад ярилцаарай. Эдгээр үгсээр өгүүлбэр зохиож бичээрэй.

Уул руу, анги руу, тэмцээн рүү, гэр лүү, үйлдвэр лүү, нар луу

Хамаатуулах нөхцөлийн утга, үүргийг мэдье.

1. Эхээс шинээр мэдэж авсан гэрийн модны нэрийг ажиглаарай. Нөхцөлүүдийн хувилбар, илтгэх утгын ялгааг тайлбарлацгаая.

- хаалга + (-ыг) + (-аа) = Хаалгаа босгоё.
- хана + (-ыг) + (-аа) = Ханаа дугуйлья.
- унь + (-ийг) + (-аа) = Униа өлгөө.
- бүслүүр+ (-ийг) + (-ээ) = Бүслүүрээ чангалъя.

- Хаалга маань(минь) хаана байна вэ? Хаалга нь хаана байна вэ?
Хаалга чинь хаана байна вэ?

2. Дараах үгсийг дээрх байдлаар гүйцээн бичиж тайлбарлая.

- тооно.....?
- дээвэр.....?
- туурга.....?
- багана.....?

3. Дээрх даалгавруудаа тайлбарлахдаа доорх ангиллыг ашиглаарай.



4.

Хамаатуулах нөхцөлийн тухай бүрэн мэдэхийн тулд дараах алхмаар даалгаврыг гүйцэтгэе.

Хамаатуулах нөхцөлийн юуг нь мэдэх вэ?	Яаж мэдэх вэ?	Зөв мэдсэн эсэхээ шалгаж үзье.
-Ямар нөхцөлүүдтэй?	-Дээрх ангиллыг ойлгох, нүдлэх	Нүдлэн тогтоосноо харилцан шалгах
-Ямар үүрэгтэй ?	-Үлгэрт дээрх нөхцөлтэй үгсийг түүж бичээд ажиглан, тайлбар хийх	А. ... нөхцөлтэй- 1 ... нөхцөлтэй -16 ... нөхцөлтэй – 1 Б. ... нөхцөлтэй -21 үг буйг олж тодорхойлох

-Ямар асуултад хариулагддаг?	-Дээрх үгстээ асуулт тавьж үзэх, асуултыг нотолж хэлэх, тодорхой ойлголттой болох	-Хамаатуулах нөхцөл нь гэсэн ялгаатай асуултуудад хариулагдана. Учир нь... -Жинхэнэ нэрийн хамаатуулах ёс гэж... зүйлийг хэлдэг.
-Эзэнд хамаатуулах нөхцөлийн онцлог?	-Төрөл олон зүйлээс нэгийг нь онцлон ялгаж үү? хэмээн хянах (харсан зүгтээ-дөрвөн зүгээс сонгосон гэх утгаар хэрэглэсэн гэх мэт ажиглах) <u>Үйлийг гүйцэтгэгч эзэнд хамаатуулж үү? гэдгийг хянах (хүүдээ хандаж- ярьж буй өвгөний хамаатай хүүхэд гэх утгаар хэрэглэсэн гэх мэтээр ажиглана)</u>	-Эзэнд хамаатуулах гэдгийн учир нь... юм. Жишээ нь, ... үгс ... ингэж хамаатжээ. (Үлгэрээс түүснээсээ 5 жишээ үг хэлэх)
- Биед хамаатуулах нөхцөлийн онцлог?	-Жинхэнэ нэрээр илэрсэн хүн, амьтан, юм, үзэгдлийг I,II,III биеийн аль нэгэнд хамаатуулж үү? гэдгийг хянах (өвгөд маань- үлгэр хэлэгч өөртөө буюу I биед хамаатуулсан)	Биед хамаатуулах гэдэг нь ...ийм учиртай. Жишээ нь:... (Үлгэрээс 5 үг олж хэлэх)

5. Үүний тулд дараах даалгавруудыг гүйцэтгээрэй.

- “Ээжийн зүүлт” шүлэгт байгаа хамаатуулах ёсны нөхцөлтэй үгсийг түүж бичээд, зөв бичих дүрмээр тайлбарлаарай.
- Хамаатуулах нөхцөлтэй дээрх үгсээ “минь, чинь, маань, -аа (-ээ,-оо, -өө) гэсэн хувилбараар хувилган утгын ялгаа, найруулгын өөрчлөлтийг тайлбарлаарай.

Ээжийн зүүлт

Хүн Та энэ хорвоод мэндлэхдээ ээжээсээ хүйгээрээ зүүлттэй
Эхийн сүү амлуутаа хөхнөөс нь зүүлттэй
Эхэлж хөлд ортлоо энгэрээс нь зүүлттэй
Хөлд орж эхлүүтээ хормойноос нь зүүлттэй
Нялх балчир үедээ нуруунд нь зүүлттэй
Ганцаараа явдаг болтлоо гараас нь зүүлттэй
Сургуулийн босго алхуутаа сурсан эрдмээс нь зүүлттэй
Эрдэм номтой болсон ч эхийнхээ сэтгэлээс зүүлттэй
Ажил хөдөлмөр эрхэлсэн ч аман сургаалаас нь зүүлттэй
Айл гэр болсон ч ач зээ нараараа зүүлттэй
Харийн оронд амьдарсан ч халуун зүрхэнд нь зүүлттэй
Хөгшин болсон хойноо ч хүүхэд хэвээрээ зүүлттэй

Буурал суусан үедээ ч бодол ухаанд нь зүүлттэй
Бурханы оронд заларсан хойно нь ч буянт үйлсээс нь зүүлттэй
Эхээс салдаггүй ийм нэгэн өхөөрдөм “хүн зүүлт”
Эгэл хорвоогийн жамаар ээж бүхэнд заяадаг ажээ.

Г.Дагва, “Өөрт чинь зориулсан шүлэг”, УБ, 2017, 24 дэх тал

6. Монгол гэр барихтай холбогдуулж хэлдэг, нэр бүхий 7 холбоо үгийг эхээс олж, гэр барих дараалалд оруулан “Би монгол гэрээ ийм дарааллаар барина” гэсэн бичил эх бичье.

Санамж: Үлгэр дотор “ханаа дэлгэж, хаалгаа босгож” ... гэх мэт холбоо үг бийг ажиглана. Мөн Гэр барих дараалал бол цаг хугацааны дараалал мөн гэдгийг давхар анхаарна.

ӨӨРИЙГЭЭ ШАЛГАЖ, ҮНЭЛЬЕ.

1. Саяын зохиосон эхдээ гэр барих дарааллыг хэр зөв тусгасныг дараах оньсогот тааврыг таах явцад хянаж үзээрэй.

Бүдүүн хүн бүсээ бүсэлж чадахгүй (Оньсогот таавар)

Манайхан “Бүдүүн хүн бүсээ бүсэлж чадахгүй”-г барих боллоо. Хамгийн түрүүнд “Сээр шиг нугалж, сэмж шиг дэлгэдэг” –ээ тойруулаад “Эгч дүү хоёр эн чацуухан”-ыг голлуулав. Тэгээд дараа нь “Чи түүгээр яв, би үүгээр явъя, Билүүтийн голд уулзъя” гэдгийг чангалж бэхэллээ. Аав “Сар шиг дугуй, сэмж шиг садархай”-г өргөн, дүү бид хоёр “Урт хар хүн уландаа үстэй”-г ойртуулж туслахад, ах эгч нар “Сар шиг дугуй, сэмж шиг садархай”-г тойруулан “Ишигний эвэр ийшээ тийшээ”-д өлгөв.

Аав “Гүн худгийн гүйдэг могой хүчтэнээс хамгаална”-д хүнд юм уялаа. Ах эгч нарт дүү бид хоёрт “Гэрээр дүүрэн гэлэнгийн олбог”-дээр дөрөөлөн гишгэж болохгүйг сануулж байлаа. *Ш. Энхбаяр*

2. Одоо оньсогыг хариутай нь харгалзуулан зурж зөв шийдлийг олцгооё.

“Бүдүүн хүн бүсээ бүсэлж чадахгүй”	<i>тооно</i>
”Сээр шиг нугалж, сэмж шиг дэлгэдэг”	<i>бүслүүр</i>
“Эгч дүү хоёр эн чацуухан”	<i>гэр</i>
“Чи түүгээр яв, би үүгээр явъя, Билүүтийн голд уулзъя”	<i>хана</i>
“Сар шиг дугуй, сэмж шиг садархай”	<i>чагтага</i>
“Урт хар хүн уландаа үстэй”	<i>ханын толгой</i>
“Ишигний эвэр ийшээ тийшээ”	<i>унь</i>
”Гүн худгийн гүйдэг могой хүчтэнээс хамгаална”	<i>хаалга</i>
“Гэрээр дүүрэн гэлэнгийн олбог”	<i>ханын нүд</i>